# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2024 он

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **1.1 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ гэрээгээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, үр дүнг Сумын Засаг даргын өмнө хариуцна.** | | | | | | | |
| 1.1.1 | Хууль тогтоомж, Засгийн газар болон харьялах дээд шатны Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах<br><br>*(Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.1)* | Улсын төсвөөр | -Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлсэн байдал<br>-Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал<br>-Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал<br>-Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг | 2023 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн | 2024 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Хугацаатай тайлан мэдээг аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох газар, хэлтэст хүргүүлж ажиллахын сацуу АЗДҮХ, СЗДҮХ хэрэгжилтийн биелэлтийг хагас болон бүтэн жилээр гаргаж цаг хугацаанд нь сумын ХЭЗХМ-д хүргүүлэн ажилласан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлсэн байдал<br>-Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал<br>-Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал<br>-Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал | | | | |
| 1.1.2 | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга), шинээр батлагдсан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тэдгээрийг байгууллага, албан хаагч, иргэд олон нийтэд сурталчлан таниулах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах | Улсын төсвөөр | -Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль<br>-Захиргааны ерөнхий хууль<br>-Хөдөлмөрийн тухай хууль<br>-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль<br>-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль<br>-Зөвшөөрлийн тухай хууль<br>-Төрийн болон орон нутгийн өмчийн | - | Хууль тогтоомжийг сурталчлах ажлыг хариуцлагатай йгаар зохион байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлсэн байна. | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга), шинээр батлагдсан 4 хууль тогтоомжийн хэрэгжилт болон эрүүл мэндийн байгууллагад мөрдөгдөж буй хууль тогтоомж, хууль эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн шинээр гарсан нийтээр мөрдөх холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудаар нийт 8 удаагийн сургалт зохион байгуулсан бөгөөд тус сургалтад 156 ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид хамрагдсан. Мөн сумын төрийн албан хаагч, олон нийтэд 11 удаагийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль<br>-Эрүүл мэндийн тухай хууль | | | сургалтыг зохион байгуулахад нийт 451 иргэн оролцсон байна. | |
| 1.1.3 | “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, иргэдийн орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ажлын зарцуулах, энэ хүрээнд уг тогтоолд заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | Улсын төсвөөр | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан байна. | - | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажилласан байна. | “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:<br>Тус эрүүл мэндийн төвийн эмчийн байранд 2 сувилагч амьдарч байгаа бөгөөд тог цахилгааны зардлыг эрүүл мэндийн төвөөс хариуцаж байна. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад олгох хөдөө орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тогтоолын дагуу бүх эмч, ажилтанд олгож байна.<br>- 2022-2024 оны хугацаанд нийт эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийг:<br>**Насны бүлгээр авч үзвэл:**<br>18-30 насны-154<br>31-45 насны-84<br>46-60 насны-777<br>61-дээш-256 нийт-1271 хүн эрт илрүүлэгд хамрагдсан.<br>**Хүйсээр авч үзвэл**: эрэгтэй-451, эмэгтэй-820 байна.<br>**Өвчлөлөөр авч үзвэл:**<br>Зүрх судасны өвчлөлтэй-636 буюу 50,0% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хоол боловсруулах эмгэгтэй-321 буюу 25,2% Хорт хавдар оношлогдсон-31 буюу 2,4% Бөөр шээсний замын өвчлөлтэй-50 буюу 0,3% Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэгтэй-145 буюу 11,4% Мэдрэлийн эрхтэн тогтолцооны эмгэгтэй-88 буюу 6.9% байна. Эмчилгээнд хамрагдаад ирсэн иргэдийг багийн эмч нар хяналтад авч эмчлэн эрүүлжүүлэн ажиллаж байна. | |
| 1.1.4 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Төрийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх | Улсын төсвөөр | -Цахимаар зохион байгуулсан худалдан авах үйл ажиллагаа тоо<br>-Цахим дэлгүүрээс худалдан авалт хийсэн тоо | | -Худалдан авах үйл ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулсан байна<br>-Төрийн байгууллагад ашиглагдах байнгын хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнийг цахим дэлгүүрээс худалдан авсан байна | Төрийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх зорилтын хүрээнд эмийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс худалдан авалтын захиалга хүргүүлсэн боловч нийлүүлэгч байгууллага нь бараа, материалын бэлтгэн нийлүүлэх хугацаа удаан, сонголт бага байсан учир цуцалсан. Харьцуулалтын аргаар эмийн худалдан авалтыг шууд худалдан авалтаар авсан. Эрүүл мэндийн газраас ерөнхий гэрээгээр 2 удаа эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендер зарласан бөгөөд 2 багц дээр эм ханган нийлүүлэх байгууллага шалгарч 4 дүгээр улиралд эм, эмнэлгийн хэрэгслийг хуваарийн дагуу хангасан. Мөн эм, эмийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгсэл ханган нийлүүлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн газартай зөвшилцсөний улмаас гэрээгээр шууд худалдан авалтаар зохион байгуулсан. | |
| 1.1.5 | Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг төрийн байгууллага бүр хангаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах | Улсын төсвөөр | -Хуулийн хэрэгжилт<br>-Ил тод байдлын үзүүлэлт | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, ил тод байдлын үзүүлэлтийг хангасан байна | Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг цахим хуудаст байршуулахын сацуу мэдээллийг самбарт тогтмол байршуулж шинэчилж ирсэн. Мөн шилэн дансны тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан зүйл заалтын дагуу санхүүгийн мэдээг сар, улирал, жилээр гаргасан төрийн сан болон эрүүл мэндийн газарт хүргүүлэхийн сацуу шилэн дансанд тогтмол байршуулсан. Мөн санхүүгийн мэдээллийг байгууллагын коридорт сар бүр ил тод мэдээллэж байна. | 90 |
| 1.1.6 | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон төрийн захиргааны төв байгууллагуудад асуудал тавихдаа сум, байгууллагаас шууд ханддаг байдлыг зогсоож, асуудлыг нэгтгэн зохих журмын дагуу аймгийн удирдлагад хүргүүлдэг байх | Улсын төсвөөр | -Хуулиар олгосон эрхийн хүрээний асуудлаар хандсан эсэх<br>-Холбогдох дүрэм, журмыг зөрчөөгүй байх | - | Хууль тогтоомжийн хүрээнд ажилласан байна. | ЭМТ нь 2024 онд сумын Засаг даргад эрүүл мэндийн төвд зориулалтын түргэний тэрэгтэй болох хүсэлт болон багийн эмч нарыг компьютержуулах хүсэлтийг уламжласны дагуу холбогдох байгууллагад сумын Засаг дарга хүсэлтийг өгснөөр энэ 2 асуудлыг шийдвэрлэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.7 | Дээд шатны байгууллагууд болон аймгийн Засаг даргаас өгсөн хугацаатай үүрэг даалгавар, тайлан мэдээ, албан бичгийн хариуг хугацаанд нь ирүүлэх, тэдгээрийг албан хэрэг хөтлөлтийн талаарх хуулогтоомж, баримт бичгийн стандартын дагуу боловсруулахад онцгойлон анхаарах | Улсын төсвөөр | Тухай бүр хугацаанд нь ирүүлсэн байдал Албан бичгийн боловсруулалтад Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-1:2021 баримт бичгийн стандартыг мөрдөж ажилласан байдал | | Тайлан мэдээ, албан бичгийг стандартын дагуу боловсруулсан байна. | Эрүүл мэндийн газар, Засаг даргын тамгын газраас 262 албан бичиг ирсэн. Үүнээс 153 хариутай бичиг ирснээс 5 бичгийн хугацаа хожимдож өгсөн 2 бичгийн хариу явулаагүй байна. Хариутай бичгийн хугацаа хоцорсон болон явуулаагүй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд анхааруулах арга хэмжээ авч ажиллалаа. | 90 |
| 1.1.8 | Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэн хариуг өгөх ажиллагааг нэг цэгээс шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, шийдвэрлэлтэд ахиц дэвшил гаргах | Улсын төсвөөр | -Хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу өгсөн байдал<br>-Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сумын Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь нэгтгэн ирүүлсэн байдал | - | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг шуурхай | Эрүүл мэндийн төвд 2024 онд нийт 7 өргөдөл хүлээн авч 100% шийдвэрлэсэн байна. Нийт 7 өргөдөл бичгээр ирснийг бүртгэл хяналтын карт үүсгэн шийдвэрлэх хугацаанд нь шийдвэрлэсэн. Нийт өргөдлийг агуулгаар нь жагсаахад 57,1% өөрийн хүсэлтээр ажлаас гарах 14,2% тэтгэвэрт гарсан ажилтан дахин ажиллах хүсэлтийн өргөдөл 28,5% ажилд орох өргөдөл ирсэн байна.<br>Мөн эрүүл мэндийн төв нь хэвтэн эмчлүүлэж байгаа | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шийдвэрлэж ажилласан байна. | үйлчлүүлэгчдээс санал хүсэлтийн дэвтэр аялуулж сарын эцэст удирдлагын багаар хэлэлцэж шийвдэрлэдэг.<br>Манай байгууллагын зүгээс ард иргэдийн санал, гомдол, өргөдөл мэдээллийг байнга хүлээн авч албан байгууллагын үйл ажиллагаагаа сайжруулахаар дараах арга хэмжээ авч, хэрэгжүүлэхээр болоод байна.<br>1.Ард иргэдэд өргөдөл, гомдол, санал хүсэлтийн талаар сургалт явуулах<br>2.Санал хүсэлтийн хайрцгийг ард иргэдийн дунд зөөврийн байдлаар явуулах<br>3.Өргөдөл гомдлыг эрүүл мэндийн төвийн бичиг хэрэгт хүний амаар болон бусдаар дамжуулан явуулахгүй байлгах /Заавал өөрийн биеэр хүлээлгэн өгдөг зөв дадлыг суулгах/<br>4.Албан байгууллагад санал хүсэлтийн хайрцгийг 3-аас доошгүй тоогоор байрлуулах<br>5.Иргэдээс ирсэн санал хүсэлтийг 7 хоног бүр шалган нягталж, байгууллагын хурал дээр танилцуулан шийдвэрлэх<br>6.Ард иргэдийн нууцлалыг хадгалж цаг тухай бүр нь хариу арга хэмжээ авдаг байх зэрэг олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхлээд байна.<br>Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр байгууллага | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэн хоорондын харилцаа улам сайжирч иргэдийн хүсэл сонирхолд нийцсэн чанартай үйл ажиллагаа цаашид тасралтгүй хүргэхэд илүү дөхөм болох юм. | |
| 1.1.9 | Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Улсын төсвөөр | Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх<br>-Хөндлөнгийн болон дотоод аудитаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төсвийн байгууллагуудад бүрэн хангуулж ажилласан байдал | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | ЭМТөв нь 2024 оны 11-р сарын 04-ны өдөр төрийн аудитид эхний 3 улирлын санхүүгийн баримтаар шалгагдсан. Завсарын аудитын дүгнэлтээр 2 зөвлөх авсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Эрүүл мэндийн төв болон эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад тухай бүр танилцуулж эрүүл мэндийн төвийн тушаал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн самбар болон цахим хаягт байршуулдаг.<br>Хандалтын тоо-1240<br>2024 онд Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг зөвлөмжлөн холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг тогтвортой хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 1.1.10 | Албаны болон хувийн ажлаар ажлын 3-аас дээш хоногийн хугацаагаар эзгүй байх тохиолдолд сумын Засаг даргад мэдэгдэж, удирдамж, хөтөлбөрөө батлуулж, зөвшөөрөл авч хэвших. | Улсын төсвөөр | -Зөвшөөрөл авсан тоо<br>-Зөвшөөрөлгүй явсан тохиолдлын тоо | - | Сумын Засаг даргад мэдэгдэж, зөвшөөрөл авч хэвшсэн байна. | ЭМТ-ийн 21 ажилтанаас 3 хоногийн чөлөө 15 ажилтан авсан байна. Мөн 3-аас дээш хоногийн чөлөө авсан ажилтан 2024 онд гараагүй байна. | 100 |
| **Зорилт 1.2.Төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцоог сайжруулан, иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.** | | | | | | | |
| 1.2.1 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, албан ёсны вэб сайт хөтлөлтийг сайжруулах, мэдээллийг тухай бүр байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байрлуулах | Улсын төсвөөр | -Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх" тухай 352 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан байдал<br>-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль<br>-Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал | | Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, шуурхай, чирэгдэлгүй хүргэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Мэдээллийг ил тод байдлыг хангах тал дээр санхүүгийн мэдээллийн самбарт сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг байршуулж ажилласан байна. Эрүүл мэндийн төв нь Yesunzuil Emt фейсбүүк хаягаар дамжуулан улирлын чанартай халдварт өвчин, шинээр тархаж буй халдварт өвчин тэдгээрээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг иргэдэд хүргэдэг. 2024 оны хувьд томуу, томуу төст өвчин, хүний папиллома вирусын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий 24, томуу томуу төст өвчин 76, бэлгийн замаар дамжих халдвар 17, элэгний В, С вирусээс урьдчилан сэргийлэх мэдээлэл 2, суулгалт халдвараас сэргийлэх зөвлөгөө 7 удаа тус | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тус фейсбүүк хаягаар дамжуулан хүргэсэн. Хандалтын тоо 1957. | |
| 1.2.2 | Орон нутгийн төрийн болон төрийн өмчит байгууллагын мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах, "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангахад хамтран ажиллах | Улсын төсвөөр | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах | | Халдлага, зөрчил гаргаагүй байх | Эрүүл мэндийн төвийн цахим группт нийгмийн эрүүл мэндийн мэдээллийг олон төрлийн мэдээ оруулдаг бөгөөд зар сурталчилгаа болон бараа, бүтээгдэхүүн сурталчлах зэргийг хориглосон тохиргоог хийсэн байдаг. 2024 оны 12 дугаар сарын байдлаар байгууллагын цахим грудд болон эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын хувийн цахим хаяг хакердуулсан зүйл байхгүй байна. | 100 |
| 1.2.3 | Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, дрограмм өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, тасралтгүй байдлыг хангаж ажиллах | Улсын төсвөөр | Техник хэрэгслээр хангасан тоо Интернэтийн хурдыг нэмэгдүүлсэн үзүүлэлт | - | Гүйцэтгэлээр | Эрүүл мэндийн төвийн эмч сувилагчын Wings программ 9-р сард худалдан авч, ЭМДЕГ, WINGS программ, ЭМТ-тэй гурвалсан гэрээ хийж ажилласан байна. Интернэтийн сүлжээний хурдны сайжруулалтыг "Монголын цахилгаан холбоо" ХХК гэрээ хийж ажиллаж байна. | 100 |
| 1.2.4 | ААХХТХ-ийн 29, 30-р зүйл Байгууллагын үйлдсэн бичиг баримтыг архивын хадгаламжийн нэгж үүсгэн хадгалж, хамгаалах, ашиглах | Улсын төсвөөр | Байгууллагын үйлдсэн бичиг баримтыг архивын хадгаламжийн нэгж үүсгэн хадгалж, хамгаалсан байна. шаардлагатай тохиолдолд архивын лавлагаа гаргаж өгсөн байна. | Архивын хадгалалт, хамгаалалтыг баримтлах журам батлагдсан. 80% | Архив хэрэг хөтлөлт ба бичиг хэргийн стандарт хэрэгжсэн байна. 100% | Архив ORG-AMS программ дээр баримт бичиг, явуулсан бичиг өргөдөл гомдолыг тус бүрээр шивэж оруулах ажлыг ажлын байрны тодоройлт, архивын баримтыг цахим хэлбэрт оруулах заалтыг зааж биелэлтийг ханган ажиллыг эхлүүлээд байна. Архивын тусгай өрөөтэй 2 тавиуртай бөгөөд техник хэрэгсэл ном | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарын авлагаар хангагдсан. Байгууллагын архивт ажилтнуудаас баримт бичгийг хуваарийн дагуу хүлээн авч архивын нөхөн бүрдүүлэлтийг жил бүр хийж ажиллаж байна. Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлэх, хэрэгжүүлэх тал дээр анхаарч байна. 2024 онд Архивын дээд шатлалын сургалтад 2 удаа хамрагдсан байна. | |
| **Зорилт 1.3. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зорилт** | | | | | | | |
| 1.3.1 | ЭМС-ийн 406 тоот тушаал, Төрийн албан хаагчийн ёс зүй болон эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах | Улсын төсвөөр | Төрийн албан хаагчийн болон эмч, эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллаж, ёс зүйн 1 сарын аян зохион байгуулах | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг судалж, ёс зүйн зөрчил гаргаагүй байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг судалж, ёс зүйн зөрчил гаргаагүй байна. | Ёс зүйн багийг шинэчлэн байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөө болон гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажиллах журам зэргийг гарган мөрдөн ажиллжа байна. Мөн ёс зүйн багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад 2 удаа хамруулсан байна. Ёс зүйн багаас эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм нийт ажилчдад сургалт зохион байгуулахад 17 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид оролцсон. Мөн Эрүүл мэндийн сайдын А/406 тоот тушаалаар батлагдсан "Ёс зүйн дүрэм"-ийг хэн сайн сурталчлан мөрдүүлэх зорилгоор зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан "Эртэч ажилтан, эерэг хандлага" үйл ажиллагаанд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид 100%, хэн нэгнийгээ гомдоосон бол түүнийгээ уучлах сэтгэлийн үгээ бичгээр болон амаар хэлэх зорилгоор "Уучлах бол ухаан" сэдэвт сургалт зохион байгуулахад нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид 100% хамрагсан байна.<br>Мөн 2024 оны байдлаар тус байгууллага нь ёс зүй, сахилга, хариуцлага алдсан 2 эмч эмнэлгийн мэргэжилтэнд Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.2, 123.2.3 дахь заалт, Төрийн албан хаагчийн ес зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.3 дах заалтыг үндэслэн нэг эмчид нь үндсэн цалинг нэг сараар 20 хувиар бууруулсан шийтгэл ноогдуулсан. | |
| 1.3.2 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгох | Улсын төсвөөр | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал<br><br>-Төрийн албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчлийн (өсөлт, бууралт) тоо | | Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 9 | Эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах зорилгоор 4 багийн эмчийг нийт 976,000 төгрөгний эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, 1,200,000 мянган төгрөгийн шатахуунаар хангаж ажилласан.<br>Мөн 20 эмч, эмнэлгийн мэргэжилтний сургалтад зориулж нийт 4261000 төгрөгний томилолт, унааны зардал, нийт 1190000 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *(Төрийн албаны тухай хуулийн 55.3)* | | -Байгууллагын ёс зүйн зөвлөл, дотоод хяналт шалгалтын ажлын чанар | | дүгээр хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу үнэлж, дүгнэсэн байна. | төгрөгний сургалтын зардлыг тус тус журам зааврын дагуу олгосон. Эмчийн байранд амьдарч байгаа 2 сувилагчийн байрны халаалтын зардалд нийт 3937680 төгрөг, цахилгааны зардалд нийт 435,000 төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Мөн ЭМТ-ийн 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдыг "Монгол даатгал"-ын гэнэтийн ослын даатгалд 2,300,000 төгрөгөөр даатгуулсан. 2024 онд хөдөлмөрийн гэрээгээр байгуулсан үүргээ чанартай сайн биелүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудыг 2019 оны 05-р тогтоол 3-р хавсралт болон албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур үнэлгээний дагуу улирал тутам дүгнэж улирлын үр дүнгийн урамшууллыг олгож байна. 2024 оны 3-р улирлын байдлаар үр дүнгийн урамшуулал нийт-37.365.660 төгрөг, гүйцэтгэлийн урамшуулал 2024 онд нэг удаа 9.618.640 төгрөг урамшуулал олгосон. | |
| 1.3.3 | АЗДҮХ 1.2.4.4.<br>СЗДҮХ 1.2.4.4.<br>Эрүүл мэндийн төвийн Эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилтнуудын улирлын урамшуулал, гүйцэтгэлийн | Улсын төсөв | ЭМС-ийн 406 тоот тушаал,<br>Төрийн албан хаагчийн ёс зүй болон эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн дүрмийг | Ёс зүйн алдаа зөрчил гаргаагүй байна. | Ёс зүйн алдаа зөрчил гаргаагүй байна. | Ёс зүйн зөрчил гаргасан 2 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд арга хэмжээ авч ажилласан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдлийг тэдгээрийн харилцаа, хандлага, ёс зүйн үнэлгээтэй уялдуулан олгодог тогтолцоонд шилжүүлэх | | мөрдөж ажилласан байна. | | | | |
| **Зорилт 1.4. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, жендэрийн тэгш эрхийг хамгаалах** | | | | | | | |
| 1.4.1 | Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралын 2022 оны 09 дүгээр сарын 21<br>АЗДҮХ 1.2.4.2.<br>СЗДҮХ 1.2.4.1.<br>хүний нөөцийн хангалт, сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих бодлого боловсруулах | Улсын төсвөөр | Хүний нөөцийн 2023-2025 хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хүний нөөцийн 2022 онд хөгжүүлэх хөтөлбөрийг биелэлт 93,8% | Хүний нөөцийн хөгжүүлэх хөтөлбөрийг биелэлт 100% | 2024 онд ажил хавсран гүйцэтгэж байгаа 3 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдэл цалин олгож ажилласан. Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу 4 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 6 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмж, 2 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тэтгэвэрт гарсны тэтгэмжийг аймгийн Эрүүл мэндийн газарт холбогдох материалыг хүргүүлснээр тэтгэмжүүдийг өгсөн бол тэтгэвэрт гарсны тэтгэмжийг байгууллагын төсвөөс үндсэн цалингаар 1 сараар тооцон 2 хүнд олгосон. | 100 |
| 1.4.2 | Хүний нөөцийн системийн хөтлөлт, ашиглалт, мэдээллийн баяжилтыг сайжруулах, улирал тутам хяналт шинжилгээ хийх, арга зүйгээр хангах, алдаатай мэдээллийг залруулах ажлыг зохион байгуулах. | Орон нутаг болон улсын төсвөөр | - Баримт бичигтэй тулган үнэн зөв мэдээллийг бүрэн оруулсан байдал<br>-Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үүрэгжүүлсэн байдал<br>-Нууцын баталгааг гаргуулсан байдал | | Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан " Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн, тоо бшртгэл хөтлөх, мэдээлэл авах журам"- | Эрүүл мэндийн төвийн СМА төрийн албаны цалингийн нэгдсэн системд нэвтрэх эрхийг авч хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж ЭМТ-ийн Нягтлан бодогч мэдээллийг төрийн албаны цалингийн нэгдсэн системд татан төрийн албан хаагчдын цалин хөлсийг тооцоолж цахимаар цалинг олгож хэвшээд байна. Хүний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ыг мөрдөж ажилласан байна. | нөөцийн системийн шинээр ажилтан ажилд орох, мэдээлэл өөрчлөгдөх тухай бүрд нь хөтлөлт, ашиглалт, мэдээллийн баяжилтыг сайжруулж алдаатай мэдээллийг залруулж ажиллаж байна. | |
| 1.4.3 | Тайлангийн жилд орон нутгийн төсвөөс хүний нөөцийн чадавхыг сайжруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Улсын төсвөөр | Хэрэгжилтийн хувиар | Гүйцэтгэлээр | Гүйцэтгэлээр | Өвөрхангай аймгийн төсвийн 99,891,993 төгрөгөөр "Өсөх ингүүмэл констракшн" ХХК-ийн ЭМТ-ийн 20 ортой эмнэлгийн барилт их засврын ажил, 4 багийн эмчид Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр 8,276,000 мянган төгрөгийн 4 ширхэг зөөврийн компьютер, дархлаажуулалтын өрөөнд Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр хүүхдийн ор, олон үйлдэлт принтер 770,000 мянган төгрөгний тоног төхөөрөмж, 2024 оны 07-р сарын 03-нд Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр /165,000,000/ өртөг бүхий land cruiser-78 маркийн иж бүрэн тоноглолтой авто машинаар хангагдсанаар иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх нөхцөлөөр хангагдан ажиллаж байна. | 100 |
| 1.4.4 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажиллах, түүнтэй холбоотой хууль, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажлын байрны бэлгийн | Улсын төсвөөр | Жендэртэй холбоотой хууль, тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байх. | 2023 онд албан хаагчдад 3 удаа сургалт явуулсан | 2024 онд сургалтын төлөвлөгөө гарган байгууллагын дотоод журманд тусгуулах. | Жендэрийн тухай ерөнхий ойлголт, жендэрт суурилсан гэр бүлийн болон, цахим хүчирхийлэл, түүнээс урьдчилан сэргийлэх, жендэрт суурилсан хүчирхийллийн хор нөлөө, хүчирхийллийг арилгах, бууруулах чиглэлийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гаргасан гомдлыг шийдвэрлэх талаар хөдөлмөрийн дотоод журманд тусган ажиллах. | | | | | мэдээлэл, зөвлөгөөг цахимаар олон нийтэд хүргэсэн. Хандалтийн тоо-350 ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилчдад ажлын байран дээрх сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх" сургалт зохион байгуулан ЭМТ-ийн 21 эмч, мэргэжилтнүүдэд сургалт хийсэн. | |
| **Зорилт 1.5. Авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, сумдын төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 1.5.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг, Авлигын эсрэг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, Байгууллагын болон сумын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа явуулж, авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх | Улсын төсвөөр | -Сумын шударга байдлын үнэлгээний хувиар<br>-Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоогоор | Сумдын шударга байдлын үнэлгээний дундаж 80.7хувь | Сумын урьд оны түвшингээс ахисан байна | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан байна. Авлигал авсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид байхгүй болно. | 90 |
| 1.5.2 | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд төрийн байгууллагын дарга нягтлан бодогч нарыг хамруулан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулах болсонтой холбогдуулан дээрх албан тушаалтнууд өөрчлөгдсөн, солигдсон тухай бүр нь ХАСУМ | Улсын төсвөөр | ХАСУМ хянуулвал зохих албан тушаалтан, хугацаандаа ХАСХОМ гаргасан албан тушаалтны тоогоор | - | ХАСУМ хянуулвал зохих албан тушаалтан, хугацаандаа ХАСХОМ гаргасан байна. | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд төрийн байгууллагын дарга нягтлан бодогч, ИТХ -ийн 4 төлөөлөгч нарыг хамруулан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулж, өөрчлөгдсөн, солигдсон тухай бүр нь ХАСУМ хянуулах, томилогдсоны дараа 30 хоногт багтаан ХАСХОМ гаргах баталгааны хуудасаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хянуулах, томилогдсоны дараа 30 хоногт багтаан ХАСХОМ гаргах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулан, хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах | | | | | баталгаажуулан ажилласан байна. | |
| **Зорилт 1.6. Иргэдэд Батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэж ажиллана. (Цэргийн бүртгэл, цэрэг татлага, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдэд сургалт явуулах, мөнгөн төлбөрийн тооцоо хийх)** | | | | | | | |
| 1.6.1 | Өсвөр болон цэргийн насны залуучуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, өвчин, эмгэгийн талаарх мэдээллийн санг бүрдүүлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах | Улсын төсвөөр | Үзлэгт хамрагдсан иргэд болон мэдээлийн санд бүрдүүлсэн байдлаар | 2023 онд 3 иргэнийг эмчлэн эрүүлжүүлсэн. | Үзлэгт иргэдийг 90-ээс доошгүй хувьтай хамруулна. | 2024 намрын ээлжит цэрэг цэргийн насны нийт 113 залуу татагдахаас 78 залуу цэргийн үзлэгт хамрагдаж, 8 залуу цэргийн албанд татагдав. Цэргийн насны залуучуудаас 1,4 дамжааны оюутнуудыг сургуулийн тодорхойлолтоор үзлэгээс чөлөөлсөн.<br>2024 онд ээлжилт цэрэг татлагт хамрагдсан залуусыг багаар нь авч үзвэл 1-р багт-20, 2-р багт-16, 3-р багт-19, 4-р багт- 23 залуучууд бүртгэгдсэн байна.<br>**Өвчлөлийн байдлаар:**<br>Гэмтэл-5, хоол боловсруулах зам-25, сэтгэц-1, шүд-26, нүд-6, чих хамар хоолой-9, зүрх судас-10, арьс-3, халдварт-0, дотоод шүүрэл-2, бөөр шээсний зам-6, яс булчингийн төрлөхийн гажиг -1, байна.<br>Цэргийн насны залуусын дундах өвчлөлийн байдлыг авч үзэхэд хоол боловсруулах замын өвчлөл, шүдний өвчлөл, зүрх судасны өвчлөл нилээдгүй илэрч байна.<br>Энэ жилээс ЭМГ-тай хамтран цэргийн насны залуучуудын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэлийг нэгдсэн байдлаар Google sheet програмаар цахижуулж, өвчлөлийг бууруулах эргэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. | |
| Зорилт 1.7 Монгол бичгийн бүх нийтийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж , уггийн бичгийн хөтлөлтийг сайжруулах | | | | | | | |
| 1.7.1 | Үндэсний бичиг үсгийг сурталчилан түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж төрийн байгууллагын албан хаагчдын монгол бичгийн чадварын түвшинг тогтоож үнэлгээнд суурилсан сургалт зохион байгуулах | Улсын төсвөөр | -Зохион байгуулсан арга хэмжээний тоо үр дүнг тооцсон байдал<br>-Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварын үнэлгээний дундаж хувь<br>-Суралцсан төрийн албан хаагчдын эзлэх хувь | 42% | 90% | 2025 оноос үндэсний бичгээр хөтлөхтэй холбогдуулан сургуулийн монгол хэл, уранзохиолын багш нартай хамтран түвшин тогтоох шалгалтуудыг авч шалгалтын мөрөөр үндэсний бичгийн сургалтыг 5 удаа зохион байгуулсан, байгууллагын албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварын үнэлгээний дундаж хувь-83%, сургалтад хамрагдсан байгууллагын албан хаагчийн эзлэх хувь-83% байна. | 90 |
| 1.7.2 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, төрийн болон ААН албан байгууллага гудамж талбайн нэр хаягыг крилл монгол бичгээр стандартад нийцүүлэн бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах | Улсын төсвөөр | -Крилл монгол бичгээр нэр хаягаа шинэчлэн бичиж байршуулсан байгууллагуудын эзлэх хувь | 70% | 100% | ЭМТ-ийн 20 болон 15 ортой гадна болон дотор өрөө тасалгааны нэр хаягыг крилл, монгол бичгээр MNS-5283-2022 стандартын дагуу 4,800,000 мянган төгрөгөөр Түмэн бүтээл ХХК хийлгэсэн байна. | 100 |
| 1.7.3 | Байгууллагын албан хаагч бүрт уггийн бичиг хөтлүүлж хувийн хэрэгт хавсаргах | Улсын төсвөөр | -Уггийн бичиг хөтлүүлж хэвшсэн байна. | | 100% | 2024 онд Соёлын төвөөс зохион байгуулсан 2 удаагийн уггийн бичиг хөтлөх сургалтад нийт 39 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, “Уггийн бичгээ хэн сайн хөтлөх вэ?” уралдаанд нийт 15 эмч, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан хамрагдаж 2 ажилтны үгийн бичиг шалгарсан. | |
| **ХОЁР: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **2.1. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.** | | | | | | | |
| 2.1.1 | АЗДҮХ 5.2.2 СЗДҮХ 1.3.1.1 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн өрөөг бий болгож, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх | Улсын төсвөөр | Нөөцийн өрөөтэй болж бэлэн байдал хангагдсан байна. | 100% | 100% | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллаж байна. Нөөцийн өрөөтэй, 1 сарын эм, эмнэлгийн хэрэгсэл нөөцтэй бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. | 100 |
| **2.2. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | |
| 2.2.1 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төлөвлөх, ага хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, үнэлгээ дүгнэлт хийж салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх | Улсын төсвөөр | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирсан байна | | Хөтөлбөр, арга хэмжээний тоогоор | Эрүүл мэндийн газарт зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд нийт 11 тайланг хүргүүлсэн. Эрүүл мэндийн төв нь нийт 8 арга хэмжээнд 4261495 төгрөг, сургалтад 1190000 төгрөг, үйл ажиллагаанд 1048505 төгрөгийг тус тус зарцуулсан байна. | 100 |
| 2.2.2 | "Эрүүл шүд, Эрүүл хүүхэд" арга хэмжээг хэрэгжүүлэх | Улсын төсвөөр | Төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн 0-18 насны хүүхдийн амны хөндийн өвчлөлийг бууруулах | 60% | 90% | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн" 2024 оны 10 сарын 03-ны өдрийн "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 14 тогтоолын 3.1.1 дэх заалтын дагуу 0-6 насны хүүхдийн 5 хүртэлх шүд, жирэмсний хяналтад буй эмэгтэй өвчилсөн бүх шүдний эмчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх бөгөөд Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төв, "Хүслэн" шүдний эмнэлэгтэй хамтран 2024 оны 12 сарын 07-10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хооронд Есөнзүйл сумын эрүүл мэндийн төвд үзлэг хийсэн. Нийт хамрагдвал зохих 260 хүүхдээс 0-6 насны 57 хүүхэд хамрагдсанаас 12 хүүхэд эрүүл, 100% эмчлэн эрүүлжүүлсэн 20 хүүхэд, 50% эмчлэн эрүүлжүүлсэн 25 хүүхэд байна. Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан ЕБС-ийн сурагчдын дунд шүдний үзлэгийг зохион байгуулж, Шүдний олимпиад, өгөгдсөн сургалтын сэдвээр ЕБС-ийн сурагчид, ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад сургалт 1-2 удаа зохион байгуулж, ЕБС-ийн 4-8 ангийн сурагчдын дундаас эрүүл шүдтэй 24 хүүхдийг | |
| | | | | | | сонгон авч шүд угаах арга, техник, амны хөндийн эрүүл ахуй, амны хөндийн арчилгааны хэрэглэгдэхүүн, Шүд цоорох өвчний өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд сэдвүүдээр ЕБС-ийн Нийгмийн ажилтан, Эрүүл мэндийн багштай хамтран өдөр бүр сургалт зохион байгуулж 1-р шатны шалгаруулалт суманд амжилттай явагдаж, 2-р шатны шалгаруулалтад оролцож Өвөрхангай аймагт 21 багаас 9 дүгээр байранд орсон. Өвөрхангай аймгийн шүдний аварга шалгаруулах тэмцээний оролцогчдын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувцасны зардлыг ЕБС, Унааны зардлыг ЭМТөв хөтөлбөрийн зардлаас 220,000 төгрөгийг хариуцан оролцлоо. | |
| 2.2.3 | Амбулаторийн тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, цаг товлох үйлчилгээг боловсронгуй болгох | Улсын төсвөөр | Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж байгаа иргэдийг ая тухтай үйлчлүүлэх нөхцлөөр хангах | | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирна | Уламжлалт сэргээн засахын кабинетад 2024 онд 5,000,000 төгрөгийн искра, 5,900,000 төгрөгийн Хатаах шүүгээ, 120,000 төгрөгийн парафины лаа 250,000 төгрөгийн бумба, дагалдах хэрэгслийг байгууллагын санхүүжилтээр тохижуулсан<br>Халдвар хяналтын сургалтад 60,000 мянган төгрөг<br>Нягтлан бодогчийг чадавхжуулах сургалтад 350,000 мянган төгрөг<br>Чанарын сургалтад 180,000 мянган төгрөг<br>Эрүүл ахуйн сургалтад 300,000 мянган төгрөг<br>2024 онд Иммулогийн аппаратыг багаж техник хэрэгслийн зардлаас 7.900.000 төгрөгөөр авч нийт 20 хүнд оношилгоо хийж хавдартай 2 хүн илрүүлж БОЭТ-д шилжүүлж эмчилгээнд хамрагдсан байна. Уушгины агаарын багтаамж 29.000.000 ЭМЯ-ны санхүүжилтээр үзэх аппараттай болсноор амьсгалын замын эмгэгтэй иргэдийг хүндрэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. 2024 оны 07-р сарын 03-нд Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр /165,000,000/ өртөг бүхий land cruiser-78 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | маркийн иж бүрэн тоноглолтой авто машинаар хангагдсанаар иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх нөхцөлөөр хангагдан ажиллаж байна. | |
| 2.2.4 | Нийт урьдчилан сэргийлэх болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | Улсын төсвөөр | -Артерийн даралт ихсэлтийн эрт илрүүлгийн (18-аас дээш нас) хувь | 75.6 | 91.0 | 93% | 90 |
| | | | -Чихрийн шижингийн эрт илрүүлгийн (40-өөс дээш нас) хувь | 92.0 | 93.0 | 95% | 90 |
| | | | -Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн (40-өөс дээш нас) хувь | 88.8 | 93.0 | 100% | 100 |
| | | | -Умайн хүзүүний эрт илрүүлгийн (30 ба түүнээс дээш ) хувь | 49.6 | 85.0 | 76% | 70 |
| | | | Нийт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь | 28.0 | 28.5 | 29% | 70 |
| 2.2.5 | Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог орон нутагтаа зохион байгуулж, үр дүнг тооцох | Улсын төсвөөр | Нийт хүн амын хамрагдалтын хувь | 52.2 | 53.2 | 47,4 | 70 |
| 2.2.6 | Хүн амын дунд тэргүүлж буй халдварт бус өвчлөл нас баралтыг бууруулах арга хэмжээг зохион байгуулах, үр дүнг тооцох (100000 хүн амд ) | Улсын төсвөөр | -Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин | 18.7 | 42.8 | 42,8 | 30 |
| | | | -Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин | 12.5 | 50.0 | 50.0 | 30 |
| | | | -Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин | 6.2 | 7.1 | 7.1 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин | 6.2 | 0 | 0 | 100 |
| | | | -Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин | 0 | 0 | 0 | 100 |
| 2.2.7 | Халдварт өвчинтэй тэнцэх, сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцох | Улсын төсвөөр | -В вируст гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь | 100 | 100 | 100% | 100 |
| | | | -Тавт (сахуу, хөхүүл ханиад, В гепатит, хөмофлюсинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь 3 дугаар тун | 94.9 | 94.9-өөс дээш | 100% | 100 |
| | | | Улаан бурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь 2 дугаар тун | 90.9 | 90.9-аас доошгүй | 93,6% | 90 |
| | | | Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (10000 хүн амд) | 2.9 | 2.4 | 2,4 | 100 |
| | | | Вирусг гепатитын өвчлөлийн түвшин (10000 хүн амд) | 0.8 | 0.6 | 0,6 | 100 |
| **2.3. Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр** | | | | | | | |
| 2.3.1. | Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Явуулын (Мобайл) | Улсын төсвөөр | Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | | Нийт насанд хүрсэн хүн амын 20-оос доошгүй хувь | 2021 онд Эрүүл мэндийн төвд 6,500,000 төгрөгийн үнэтэй зөөврийн эхо аппарат, 2 сая төгрөгийн үнэтэй blackview үйлдвэрийн таблетаар хангасан. Зөөврийн эхо аппаратаар 2024 оны 12-р | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрүүл мэндийн тусламж үйлчилгээ"-г зохион байгуулах | | | | | сарын байдлаар алсын дуудлагад 23 удаа ослын дуудлагад 5 удаа эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй тасралтгүй үзүүлсэн байна. Сумын засаг дарга Т.Бат-өлзийгөөр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй баг Эрээний 4 дүгээр багт 7 хонгийн хугацаанд 200 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийснээс Эрэгтэй-115, Эмэгтэй-85 үүнээс: Элэг цөсний эмгэгтэй-115, Эрүүл-10, Бөөр шээсний замын эмгэгтэй-65, Цөсний чулуутай-1 БОЭТ-д хагалгаанд оруулсан, Элэгний хавдартай-2 Онош тодруулан эмчилгээнд хамруулсан, Нойр булчирхайн архаг үрэвсэлтэй-7 байна. Нийт өвчтэй илэрсэн 186 иргэнийг хяналтад хамруулж 4 иргэнийн эрүүл мэндийн төвд хэвтүүлэн эмчилсэн байна. | |
| 2.3.2 | Сумын эрүүл мэндийн төвийн барилгыг цэвэр, бохир шугамын асуудлыг шийдвэрлэх | Улсын төсвөөр | Шийдвэрлэлтийн хувь | 70.0 | 100.0 | Цэвэр бохирт одоогоор холбогдоогүй байгаа. Сумын засаг дарга болон эрүүл мэндийн газраас судалгаа авч эрүүл мэндийн яам, аймгийн засаг даргад удаа дараа хүсэлт тавьсан боловч шийдвэрлэгдээгүй байна. | 100 |
| **2.4. Эх, хүүхэд нөхөн үржихүйн чиглэлээр** | | | | | | | |
| 2.4.1 | Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлж, чанарыг | Улсын төсвөөр | -Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлт тутамд) | 0 | 0 | 0 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулан, гурвалсан халдварын шнжилгээнд хамруулж, эрүүлжүүлэх ажлыг салбар дундын оролцоотойгоор зохион байгуулах | | -Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт) | 0 | 0 | 0 | 100 |
| | | | -Жирэмсний эрт үеийн хяналтын хувь | 93.5 | 96.5 | 85,7 | 70 |
| | | | -Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд) | 0 | 0 | 0 | 100 |
| | | | -Гурвалсан халдварын шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь | 95.0 | 100.0 | 100 | 100 |
| 2.4.2 | Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулах | Улсын төсвөөр | -Нялхасын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт) | 0 | 0 | 0 | 100 |
| | | | -5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт) | 0 | 0 | 0 | 100 |
| | | | -0-5 хүртлэх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин (10000 хүүхдэд) | 0 | 0 | 0 | 100 |
| | | | Өсвөр насны 1000 эмэгтэйд ноогдох төрөлтийн түвшин | 0 | 0 | 0 | 100 |
| | | | 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэндийн цогц үзлэг хийсэн хувь | - | 50%-аас дээш | 100 | 100 |
| **ГУРАВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ АРГА ХЭМЖЭЭ:** | | | | | | | |
| 3.1.1 | Төсвийн тухай хууль Аймгийн ЗД-тай сумын ЗД-ын байгуулсан гэрээний 1.1.3 | Улсын төсвөөр | Мэдээ, мэдээллийг цахим хуудас /www.shilendans.gov.mn/-т тухай бүр | Төсвийг зориулалтын дагуу зарцуулж төсвийн хэтрэлт | Төсвийг зориулалтын дагуу зарцуулж | "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хханган ажиллаж байна. Төсвийн гүйцэтгэлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтыг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, хариуцлага урамшууллын тогтолцоог бий болгох, төсөв хэтэрч, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангах | | мэдээлж, "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллсан байна. | гаргалгүй ажилласан байна. Шилэн дансны мэдээллийг хугацаа хожимдуулж оруулсан. 96% | төсвийн хэтрэлт гаргалгүй ажилласан байна. 100% Шилэн дансанд мэдээллийг тухайн бүрд үнэн зөв байршуулсан байна. 100% | сарын мэдээг төрийн санд сар бүрийн 02-ний өдрийн дотор гарган өгч шилэн дансанд мэдээлэлээ сар бүрийн 06-с өмнө байршуулж, ажиллаж байна. | |
| 3.1.2 | Эрүүл мэндийн төвийн тохижилт, дэд бүтцийг сайжруулахад анхаарч орон нутгаас дэмжлэг үзүүлж ажиллах | Улсын төсвөөр | Дэмжлэг үзүүлж хамтран ажилласан арга хэмжээний тоо үр дүн | | 1-2<br>90-ээс дээш | -Өвөрхангай аймгийн төсвийн 99,891,993 төгрөгөөр "Өсөх ингүүмэл констракшн" ХХК-ийн ЭМТ-ийн 20 ортой эмнэлгийн барилгат их засврын ажил хийж гүйцэтгэсэн.<br>-Хайрхан, Эрээний багуудын багийн эмч нарт Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр 8,276,000 мянган төгрөгийн 4 ширхэг зөөврийн компьютер.<br>-Дархлаажуулалтын өрөөнд Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр хүүхдийн ор, олон үйлдэлт принтер 770,000 мянган төгрөгний тоног төхөөрөмжөөр хангагдсан.<br>-2024 оны 07-р сарын 03-нд Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр /165,000,000/ өртөг бүхий land cruiser-78 маркийн иж бүрэн тоноглолтой авто машинаар хангагдсанаар иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | алдалгүй хүргэх нөхцөлөөр хангагдан ажиллаж байна. | |
| 3.1.3 | Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн хангалтыг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэн,орон нутгийн нөөц боломжийн хүрээнд дэмжлэг туслалцаа үзүүлэх | Улсын төсвөөр | -Шинээр ажилд авсан эмч мэргэжилтний тоо<br>-Нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн арга хэмжээ | | 1-2 гүйцэтгэлээр | -Шинээр ажилд авсан -2<br>-Нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн арга хэмжээ-6<br>1.Эрүүл мэндийн төвийн санхүүжилтээр 976,000 эмчийн үзлэгийн багц,1,200,000 мянган төгрөгийн шатахуунаар ханган ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>2.Багийн эмч нарыг чадавхжуулах сургалтад Эрүүл мэндийн төвөөс томилолт болон замын зардлыг байгууллагын санхүүжилтээс гарган Улаанбаатар хотод 1, Өвөрхангай аймагт-1 удаагийн сургалтад хамруулж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.<br>3.2024 онд шинээр 1 сувилагч ажилд авч ажиллуулж байгаа. Эмчийн байранд 2 сувилагч амьдарч байна. Сувилагчийн байрны халаалтын зардал 8-сараар 300м2*1640.7=492,210 төгрөг сард төлж байгаа. Цахилгааны зардал 12 сараар нийт 435,000 төгрөг төлж дэмжлэг үзүүлж байна. О.Намсрай эмч 2022.09-р сард Сумын эрүүл мэндийн төвд Их эмчээр ажилд орсон. Сумын эрүүл мэндийн төвийн зүгээс О.Намсрай эмчийн гэр бүлийн хүнийг ажлын байраар хангаж Нийгмийн эрүүл мэндийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилтнаар авч ажиллуулж байна.<br>4.ЭМТ-ийн 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдийг гэнтийн ослийн даатгалд "Монгол даатгал" –д 2,300,000 даатгуулсан.<br>5.Эрүүл мэндийн төвийн ажилтнуудын улирлын урамшуулал, ур чадварын нэмэгдлийг тэдгээрийн харилцаа, хандлага, ёс зүйн үнэлгээтэй уялдуулан 2019 оны 05-р тогтоол 3-р хавсралт болон албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур үнэлгээний дагуу улирал тутам үр дүнгийн урамшуулал олгож байна. 2024 оны 3-рулирлын байдлаар үр дүнгийн урамшуулал нийт-37.365.660 төгрөг, гүйцэтгэлийн урамшуулал 2024 онд нэг удаа 9.618.640 төгрөг урамшуулал олгосон.<br>6.Хөтөлбөрийн зардлаас сургалтад:<br>Архивын ерөнхий газраас Архивын ажилтныг чадавхжуулах сургалтад 300,000 мянган төгрөг<br>Халдвар хяналтын сургалтад 60,000 мянган төгрөг<br>Нягтлан бодогчийг чадавхжуулах сургалтад 350,000 мянган төгрөг<br>Чанарын сургалтад 180,000 мянган төгрөг<br>Эрүүл ахуйн сургалтад 300,000 мянган төгрөг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4 | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгааг зохион байгуулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх ажлыг салбар дундын хамтын оролцоотойгоор зохион байгуулж, үр дүнг тооцох | Улсын төсвөөр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 3-5 | 1. "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн" 2024 оны 10 сарын 03-ны өдрийн "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 14 тогтоолын 3.1.1 дэх заалтын дагуу 0-6 насны хүүхдийн 5 хүртэлх шүд, жирэмсний хяналтад буй эмэгтэй өвчилсөн бүх шүдний эмчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх бөгөөд Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төв, "Хүслэн" шүдний эмнэлэгтэй хамтран 2024 оны 12 сарын 07-10 хооронд Есөнзүйл сумын эрүүл мэндийн төвд үзлэг хийсэн. Нийт хамрагдвал зохих 260 хүүхдээс 0-6 насны 57 хүүхэд хамрагдсанаас 12 хүүхэд эрүүл, 100% эмчлэн эрүүлжүүлсэн 20 хүүхэд, 50% эмчлэн эрүүлжүүлсэн 25 хүүхэд байна.<br>2. Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан ЕБС-ийн сурагчдын дунд шүдний үзлэгийг зохион байгуулж, Шүдний олимпиад, өгөгдсөн сургалтын сэдвээр ЕБС-ийн сурагчид, ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад сургалт 1-2 удаа зохион байгуулж, ЕБС-ийн 4-8 ангийн сурагчдын дундаас эрүүл шүдтэй 24 хүүхдийг сонгон авч шүд угаах арга, техник, амны хөндийн эрүүл ахуй, амны хөндийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арчилгааны хэрэглэгдэхүүн, Шүд цоорох өвчний өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд сэдвүүдээр ЕБС-ийн Нийгмийн ажилтан, Эрүүл мэндийн багштай хамтран өдөр бүр сургалт зохион байгуулж 1-р шатны шалгаруулалт суманд амжилттай явагдаж, 2-р шатны шалгаруулалтад оролцож Өвөрхангай аймагт 21 багаас 9 дүгээр байранд орсон. Эрүүл шүд" арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, ЕБС-ийн нийгмийн ажилтантай хамтран ЕБС-ийн сурагчид шүд угаах арга ppt сургалт 110 хүүхэд хамрагдаж шүд зөв угаах дадалд суралцлаа. Өвөрхангай аймгийн шүдний аварга шалгаруулах тэмцээний оролцогчдын хувцасны зардлыг ЕБСургууль, Унааны зардлыг ЭМТөв хөтөлбөрийн зардлаас 220,000 төгрөгийг хариуцан оролдлоо<br>3. Хүн амын эрүүл зөв хооллолтын хэрэглээг үнэлэх, мэдлэг, хандлагын судалгаа хийж нотолгоонд суурилсан арга хэмжээг зохион байгуулав. Зөв хооллолт, эрүүл аюулгүй хүнсийг бэлтгэж, хэрэглэх талаар хийх үйл ажиллагааны удирдамжийн дагуу доорх ажлуудыг хийлээ. Үүнд:Төрийн болон төрийн бус албан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчид Сумын хэмжээнд бүртгэлтэй 5 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний ар гэрийнхэн цэцэрлэгийн тогооч, ЕБС-ийн тогооч давсны хэрэглээг бууруулах, насанд тохирсон давсны хэрэглээний талаар сургалт хийж 5 хүүхэд, 8 эцэг эхчүүд, гал тогоо бүхий газруудын тогооч нарыг хамруулав. Нийт иргэдэд Эрүүл зөв хооллолт, хүнсийг зөв бэлтгэн хэрэглэх талаар сургалт зохион байгуулж 126 хүнийг хамруулсан. Эмнэлгийн 16 эмч мэргэжилтнүүдэд "Давсны зөв хэрэглээ", "хүнсний бүтээгдэхүүний шошго дээрх давсны агууламжийг хэрхэн харах вэ? сэдвээр дотоодын сургалт зохион байгуулж, сургалтын өмнө ба дараа хоногт хэрэглэх давсны хэмжээ, хэд байх талаар мэдлэг сорих асуултад сургалтын өмнө 65,5 сургалтын дараа 85,5% болж өссөн байлаа. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэд болон ахмад настанд хөдөлмөр халамжийн мэргэжилтэд халамжийн тухай хууль тогтоомжийн "Давсны зөв хэрэглээ", "Хүнсний бүтээгдэхүүний шошго дээрх давсны агууламжийг хэрхэн харах вэ?" сэдвээр сургалтыг зохион байгуулж 48 хүнийг хамруулсан. Давсны хэрэглээг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бууруулах сургалтыг хэвтэн эмчлүүлэгч 12 хүнд 2 удаа нарны алхалтад алхаж буй 36 иргэнд 3 удаа сургалт зохион байгууллаа. Сургалтын үр дүнд иргэдийн эрүүл мэндийн боловсрол 70% нэмэгдсэн. Хүнсний бүтээгдэхүүний сав,баглаа, боодолд харшил үүсгэдэг орц бүрдүүлэгчийг зөв таних, талаар иргэдэд сургалт сурталчилгаа хийсэн. Хүнсний худалдаа эрхэлж буй 3 дэлгүүрийн ажилтнуудад 3 удаа 7 хүнд мэдээлэл, сурталчилгаа хийсэн. Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн 10 хүнд 1 удаа сургалт зохион байгуулж ажилсан байна.<br>Эрүүл зохистой хооллолтын талаар мэдлэг олгох зорилгоор сургалт Сургалтын явцад аль болох нээлттэй ярилцаж түргэн гэмтдэг хүнсний бүтээгдэхүүний талаар болон аминдэмээр баялаг хоол, хүнсний ногооны ач холбогдол, хэрхэн зөв хадгалж хоол хүнсэндээ хэрэглэх, давсны хэрэглээг бууруулах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан. Мөн түүнчлэн бэлэн болон бэлэн бус бүтээгдэхүүний илчлэгийг тооцон танилцуулж аль болох түргэн хоол хүнс хэрэглэхгүй байх талаар зөвлөгөө өгсөн. Зарцуулсан төсөв-215,315 байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. Томуу, томуу тест өвчнийг бууруулах зорилгоор зорилтот насны 140 иргэнийг томуугийн вакцинжуулалтад хамруулсан. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг цахимаар нийт 21 удаа явуулсан. Томуу, томуу төст өвчнийг бууруулах зорилгоор 0-5 насны хамрагдвал зохих-94 хүүхдээс хамрагдсан-94 хүүхэд, зорилтот бүлгийн хамрагдвал зохих-24, хамрагдсан-24, жирэмсэн хамрагдвал зохих-2, хамрагдсан-2, эмнэлгийн эмч, мэргэжилтэн-21 хамрагдахаас 21 хамруулсан иргэнийг томуугийн вакцинжуулалтад 100% хамруулсан.<br>5. Халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйл болох архи, тамхи, сэтгэцийн эрүүл мэндийн талаар ухуулга, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулан. Дотуур байрны ахлах ангийн 78 сурагчдад "Согтууруулах ундааны хор уршиг" "Дам тамхидалт" "Электрон тамхины хор уршиг"сэдвээр сургалт зохион байгуулж ажилласан.<br>6. Орчны эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг 4 чиглэлээр гаргаж хөтөлбөрийн хэрэгжилт 100% биелсэн байна. Хогийн цэгт эмнэлгийн зориулалттай хог устгах цэг, ЭМТ-ийн хуучин | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилгийн суурь цэвэрлэхэд Зарцуулсан санхүүжилт 3,576,180 төгрөг байна.<br>7. Нялх бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөөний хүрээнд Миний ээж бүгдийг чадна өдөрлөгийг зохион байгуулсан. Зарцуулсан зардал 139,000 төгрөг<br>8. Дэлхийн усны өдрийн арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд "Усыг хайрлан хамгаалъя аян зохион байгуулсан" ЕБСургуулийн 84 сурагч 7 багш ажилчдад "Усаа хайрлая усны гайхамшиг" сэдэвт сургалтыг ЗДТГ хамтран АХА, Гар зургийн уралдаан зохион байгуулсан. Зарцуулсан санхүүжилт 110,000 мянган төгрөг байна. | |
| **ДӨРӨВ.БАЙГАЛЬ ОРЧИН** | | | | | | | |
| 4.1.1 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд мод тарьж арчилж, ургуулах ажлыг нарийвчилсан судалгаа, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж, мод тарих үйл ажиллагаанд хувийн хамт олноо оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа авах; | Улсын төсвөөр | -Тарьсан модны тоо, ургалтын хувь<br>-Мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн байдал | 2023 онд 500 мод тарьсан | 2024 онд 1000ш модтой болсон байна. | ЭМТ-ийн гадаад талбайд 1000 ш мод тарьсан 100% ургасан байна. | 100 |
| 4.1.2 | Сумын хогийн цэгт эрүүл мэндийн төвийн халдвартай хог хаягдлыг устгах цэгийг сайжруулах | Улсын төсвөөр | Хөрсний бохирдолт буурна. | | Зориулалтын хог хадгалах цэгтэй болсон байна. | Орчны эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг 4 чиглэлээр гаргаж хөтөлбөрийн хэрэгжилт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 100% биелсэн байна. Хогийн цэгт эмнэлгийн зориулалттай хог устгах цэг, ЭМТ-ийн хуучин барилгийн суурь цэвэрлэхэд Зарцуулсан санхүүжилт 3,576,180 төгрөг байна. | |
| 4.1.3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан гадна талын тохижилт үйлчилгээг хийх | Улсын төсвөөр | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирна | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчүүлэх орчин сайжирна. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шат, ариун цэврийн өрөөтэй болсон. | 100 |
| Нийт үнэлгээ | | | | | | | 94 |
| Дээд шатны байгууллагын үнэлгээ | | | | | | | |

**ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ХЯНАСАН: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ**

**Тэмдэг** **ЗАСАГ ДАРГА** /................................................/ **Ц.МЯГМАРСҮРЭН**

**/Албан тушаал/**

**ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ**

**Тэмдэг** **ДАРГА** /................................/ **Ж.ХОРОЛСҮРЭН**

**/Албан тушаал/**

**2024-12-23**